

**ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг)	Тайлбар
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо/ажлын байран дахь /	5-аас дээш	ЗДТГ-аас 62, ЭМТ-өөс 10, соёлын төвөөс 8, цэцэрлэгээс 4, ЕБС-аас 14 удаагийн дотоод сургалтыг зохион байгуулж салбарын талаарх мэдээ мэдээлэл, хууль эрх зүйн актыг танилцуулах, сурталчлах, цаг үеийн ажлын талаар мэдээлэл хийлээ.	10520.9	
			Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	Сургалт, мэдээлэл, дотоод сургалтанд албан хаагчдыг 100% хамруулж ажилласан.		
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал/ Гадаад буюу улс, бүс/	20 хувиас дээш	ЗДТГ-аас 9 албан хаагч, соёлын төвийн 4 албан хаагч, ЭМТ-өөс давхардсан тоогоор 12 эмч, мэргэжилтэн, ЕБС-ийн 22 багш ажилтан, цэцэрлэгийн 3 багш, ажилтан нийт 50 албан хаагч улс, аймаг, бүсийн сургалтанд хамрагдсан ба энэ нь нийт төрийн албан хаагчдын 66,6 %-ийг эзэлж байна. 1 албан хаагч магистрын хөтөлбөрт, 2 албан хаагчийг дээд боловсрол эзэмшихэд нь дэмжиж ажиллалаа. Хэрэгжилт 100%		Томилолт Замын зардал Сургалтын төлбөр
	2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан	70 хувиас дээш	Тус сумын төрийн байгууллагад ажиллаж байгаа 75 албан хаагч байгаагаас 3 ба түүнээс дээш жил ажилласан 51 албан хаагч байна. Энэ нь нийт албан хаагчдын 68%-ийг эзэлж байна.	-	

			мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт		Хэрэгжилт 100%		
			Хэсгийн дундаж: 100%				
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Ажлын үр дүнг харгалзан шагналд тодорхойлсон байдал	ЭМЯ-ны жуух бичиг, Эрүүл мэндийн тэргүүний ажилтнаар, БСШУЯ-ны жуух бичгээр тус бүр 1 албан хаагч шагнагдсан. Сангийн яамны жуух бичгээр шагнуулахаар 3 албан хаагчийн материалыг СТСХ-т хүргүүлсэн. 1 албан хаагч “Заах аргач” зэрэгтэй болсон.	-	-
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиул ах	Гүйцэтгэлээр	ЗДТГ-аас 3, цэцэрлэгээс 1 албан хаагчийн ажлын үр дүнг харгалзан шатлал ахиулах шийдвэр гаргасан. ЗДТГ-аас 9, ЭМТ-өөс 16, ЕБС-ийн 25 албан хаагчид улирлын ажлын үр дүнг үнэлэн 25-60%-иар тооцон улирлын үр дүнгийн урамшуулал олгож ажилласан. Төрийн үйлчилгээний 20 ажилтанд сар бүр ажлыг дүгнэн ур чадварын нэмэгдлийг олгосон. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10, зэрэг дэвийн нэмэгдлийг 1 албан хаагчид олгож ажилласан. Мөн 45 албан хаагчид түлээ түлшний хөнгөлөлт олгосон. Энэ онд 1 төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг харгалзан зэрэг дэв ахиулах материалыг аймгийн ТАСЗ-д хүргүүлж шийдвэрлүүлсэн. Хэрэгжилт 100%	131783,5	Үр дүнгийн урамшуулал, хөнгөлөлт, тусламж Нэмэгдэл, ур чадвар
	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Санал асуулгын мөрөөр ажил зохион байгуулж үр дүн гарсан байх	ЗДТГ-ын дотоод хяналтын нэгжээс албан хаагчдын дунд ажлын байрны орчин, сэтгэл ханамжийн талаар 8 асуулгаар санал асуулга авсан. Санал асуулгын дүнгээс харахад ажиллах орчин нөхцөл, өрөө тасалгааны тохижилтын талаар 40% нь сайн, 60% нь дунд, тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй байдлын талаар 53%		Засвар тохижилтонд зарцуулсан урсгал засварын хөрөнгө

				нь дунд зэрэг, 40% нь сайн, 7% нь муу, байгууллагаас үзүүлдэг нийгмийн хангамжийн дэмжлэг туслалцааны талаар 87% нь сайн, 13% нь дунд, удирдлагуудын зүгээс ажилтны ажлыг дэмжиж, тусалж идэвхжүүлдэг талаар 67% сайн, 33% дунд, ажлын сэтгэл ханамж 80% сайн, 20% дунд, ажилтнууд хоорондын ажлын уялдаа холёоо, харилцаа, хандлага, ёс зүйн талаар 73% сайн, 27% дунд гэж үзсэн байна. Санал асуулгын мөрөөр ЗДТГ-т мэргэжилтнүүдэд 5ш зөөврийн компьютер, архивт төмөр шүүгээ, зөөврийн болон суурин халуун хэмжигч авч байршуулан, мэдээллийн самбаруудыг шинэчиллээ. ЕБС-аас улирал бүр багш ажилчдын үр дүнгийн тайлангийн хурлын үеэр нийт багш ажилчдаас ажлын байрны талаар сургуулийн захиргаанд тавих санал хүсэлтийг авч дараа улиралд нь шийдвэрлэж өгдөг. Тоглоомын талбайг ОНХС-ийн 8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр бий болгосон.	14139,7	
					6787,7	



Сургуулийн хашааг шинээр барьж үүдэндээ 4 сандал, хогийн сав хийж талбайг цементлэсэн.



Сургууль, дотуур байрны үүдэнд туузан гэрэл мөн сургуулийн гадна орчинд гэрэлтүүлэгтэй болсон. Актлагдсан складыг буулгаж, суурийг цэвэрлэн хашаагаа томсгож барьж янзалсан. 3м гүнтэй нүх ухаж дотор талыг модоор доторлож муу усны нүхтэй боллоо. Сургууль, дотуур байрны гадна талд авто зогсоол, тэмдэг тэмдэглэгээ хийлээ. Усан оргилууртай боллоо.



Сургууль, дотуур байрны үүдэнд туузан гэрэл мөн сургуулийн гадна орчинд гэрэлтүүлэгтэй болсон. Актлагдсан складыг буулгаж, суурийг цэвэрлэн хашаагаа томсгож барьж янзалсан. 3м гүнтэй нүх ухаж дотор талыг модоор доторлож муу усны нүхтэй боллоо. Сургууль, дотуур байрны гадна талд авто зогсоол, тэмдэг тэмдэглэгээ хийлээ. Усан оргилууртай боллоо.

				 ЭМТ-ийн 15 албан хаагчаас ажлын байрны сэтгэл ханамж, тав тухын судалгаа авсан. Үүнээс 80 хувь нь ажилчидын ажлын байрны тав тух муу, гадны гэрэлтүүлэг бага, дархлаажуулалт, нярав, эх барихын өрөөний хана өнгө үзэмж муу гэсэн дүгнэлт гарсан. Санал асуулгын дүнд 3-р улиралд ажилчдын алжаал тайлах өрөөнд шинээр зурагт, антенъ байршуулан, хулдаасан шалыг дрожлон гадна үүдний гэрэлтүүлгийг шинээр нэмж, гадна нойлд мэдрэгчтэй гэрэл байршуулсан. Дархлаажуулалт, эх барих, няравын өрөөний ханыг имульдэж будсан. Албан хаагчидын ажлын байрны сэтгэл ханамж дээшилсэн. Хүүхдийн цэцэрлэгээс сургалтын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр “Багш хөгжлийн төв” 230000 төгрөгөөр тохижуулан шинээр байгуулсан. Удирдлага, багш нарт албан хэрэгцээнд 5248500 төгрөгийн 3ш нээтбүүк, бүлгүүдэд 952000 төгрөгийн тоглоом наадгайгаар хангасан. Багш ажилчдаас ажлын байрны ая тухтай байдлын судалгааг авахад:	5150,0	
					6430,5	

				- Ажлын байрны ая тухтай байдал, эрүүл ахуй, орчинд - сэтгэл хангалуун - Ажлын байранд хэрэглэгдэх тавилга, техник, тоног төхөөрөмжийн хангалт – хангалттай - Ажлын байрны уур амьсгал, удирдлагаас багш ажилчидтай харьцах харьцаанд – сэтгэл хангалуун Цаашид шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг авч, өнгөт А3 принтерын тоог нэмэх, гал тогоог тоног төхөөрөмжөөр хангах, багшийн хөгжлийн төв, урлаг заал, үүдний өрөөг тохижуулах, шинээр цэцэрлэгийн барилгатай болох талаар гарсан саналыг 2021 оны төлөвлөгөөнд тусган ажиллахаар боллоо. Соёлын төвийн дотоод хяналтын нэгжээс албан хаагчдын дунд ажлын байрны орчин, тохижилтын талаар санал асуулга авсан. Санал асуулгын дүнгээс харахад байгууллагын дотоод орчны нөхцөл, өнгө үзэмж сайжирч ая тухтай ажиллах нөхцөл бүрдэж байгаа гэсэн байна. Мөн байгууллагаа цэцэгжүүлэх санал гарч 6 цэцгийг шинээр үрслүүлж тариад байна. Хэрэгжилт 100%	-	
		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардал	Гүйцэтгэлээр	ЭМТ-өөс албан хаагчиддаа өдрийн 1000 төгрөгөөр тооцож хоолны мөнгө олгож байна. Бусад байгууллагаас хоол унааны зардал төсөвт суугдаагүй учир олгогддоггүй.	3241,5	Хоолны мөнгө
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах,	Эрүүл мэндийн урьдчилан	Жилд 1-ээс доошгүй удаа	2020 оны 11 сард Дундговь аймгийн нэгдсэн эмнэлгээс ирсэн эмэгтэйчүүд, дотор, ЭХО, хүүхэд, шүд, мэдрэл зэрэг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 72 албан хаагчийг хамруулж 3 төрлийн	668,4	Замын зардал

		урьдчилан сэргийлэх	сэргийлэх үзлэг		шинжилгээ буюу цээжний рентгэн, биохими, дотрын ЭХО-нд хамрагдсан. ЕБС, ЭМТ, цэцэрлэгийн тогооч, жижүүр, бага ангийн багш зэрэг 18 албан хаагч Дундговь аймгийн НЭ-т нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношлогоонд хамрагдсан.		
			Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	1 удаагийн үзлэгт 15 албан хаагч хамрагдсан. Хэрэгжилт 100%		
		Хэсгийн дундаж: 100%					
	Үнэлгээний дундаж хувь: 100%						